



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар A/24

Халбан

**Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт  
шилжүүлсэнтэй холбогдуулж  
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дахь заалт, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор сумын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит сумын байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг багийн Засаг дарга нар, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг багийн Засаг дарга нар, байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай

3.1.Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор "Малчдадаа тусалъя аян"-ыг сумын хэмжээнд зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

3.2.Сумын шуурхай штабт ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин, илүү цагийн хөлсийг тооцож олгох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т даалгасугай.

3.3.Малын сэг, зэм устгахад шаардагдах ариутгал, халдваргүйтгэлийн бодис, гоц халдварт өвчний вакцин, шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэх, татан авах, ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Н.Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

3.4.Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин айл өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.5.Малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд газар дээр нь мэргэжлийн баг томилон ажиллуулах, эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга

2.

3.6. Хүнсний тусламж, малын тэжээл хуваарилах, хяналт тавих ажлыг шуурхай зохион байгуулахыг Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-т даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

